

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2025/043-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-14
4. Аудитын тайлан	14-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ГӨРНИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг Цагаан эрэг Сүхбаатар сум  
Сэлэнгэ аймаг 43081  
Утас-Факс (976) 7036 3040  
Цахим шуудан Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ПРОКУРОРЫН  
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ө.САЯНЖАМЦ ТАНАА

2025.02.14 № СЭА-2025/043-НА-СТА-ТШЗ

тантай

-ны №

-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд УЕПГ-аас үнэ төлбөргүйгээр 227,980.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

### Аудитын гол асуудал

Тус Прокурорын газрын төсвийн шууд захирагч буюу Тамгын хэлтсийн даргын албан тушаалыг 2024 оны 4 дүгээр сарыг хүртэл аймгийн Ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Б.Эрхэмбаатар хавсран гүйцэтгэж байсан бол МУЕП-ын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/252 дугаар тушаалаар прокурорын туслах ажилтан-ахлах мэргэжилтэн Б.Цэцэгмааг түр орлон гүйцэтгэгчээр томилсон зэргээр төсвийн шууд захирагчийг хавсран гүйцэтгүүлж байгаа нь хөрөнгө, мөнгөний зарцуулалтад тавих хяналтыг сулруулах эрсдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,279,965.6</b>	<b>12,209,701.6</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	14,279,965.6	12,209,701.6
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	14,279,965.6	12,209,701.6
35410	Бичиг хэргийн материал	3,249,500.0	2,850,550.0
35420	Аж ахуйн материал	6,430,200.0	3,232,900.0
35440	Түлш, шатах тослох материал	371,465.6	578,901.6
35470	Бусад хангамжийн материал	4,228,800.0	5,547,350.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>791,354,511.8</b>	<b>941,782,903.1</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	791,354,511.8	941,782,903.1
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	786,657,011.8	937,415,403.1
39201	Барилга, байгууламж, орон сууц	669,602,340.0	669,602,340.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,925,122.8)	(67,110,147.4)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,800,000.0	259,044,444.4
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44,877,083.6)	(47,101,713.2)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,372,510.8	174,946,310.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,072,549.9)	(100,507,836.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,200,968.8	94,417,885.8
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,453,051.5)	(45,884,880.9)
39217	Ном	9,000.0	9,000.0
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,697,500.0	4,367,500.0
39301	Програм хангамж	1,320,000.0	1,320,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(522,500.0)	(852,500.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,900,000.0	3,900,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>805,634,477.4</b>	<b>953,992,604.7</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>805,634,477.4</b>	<b>953,992,604.7</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	805,634,477.4	953,992,604.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,943,025.0	275,943,025.0
51101	Өмч: - төрийн	275,943,025.0	275,943,025.0
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	499,661,258.9	648,019,386.2
51210	Өмнөх үеийн үр дүн	499,661,258.9	499,661,258.9
51220	Тайлант үеийн үр дүн	-	148,358,127.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,030,193.5	30,030,193.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>805,634,477.4</b>	<b>953,992,604.7</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>818,626,820.0</b>	<b>1,600,028,377.4</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,547,420.0</b>	<b>239,435,877.4</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,547,420.0	239,435,877.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,547,420.0	239,435,877.4

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>812,079,400.0</b>	<b>1,360,592,500.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	812,079,400.0	1,360,592,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	812,079,400.0	1,360,592,500.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>868,713,797.6</b>	<b>1,451,670,250.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>868,713,797.6</b>	<b>1,451,670,250.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>814,554,780.6</b>	<b>1,336,021,145.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>569,758,706.1</b>	<b>995,065,984.4</b>
210101	Үндсэн цалин	315,231,310.5	572,447,110.2
210102	Нэмэгдэл	164,297,640.2	280,970,165.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,253,000.0	62,361,000.0
210104	Урамшуулал	51,477,042.8	79,287,709.0
210105	Гэрээт ажлын хөлс	7,499,712.7	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,288,762.9</b>	<b>124,045,430.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,228,027.5	84,417,459.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,556,238.6	9,955,479.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,414,190.8	4,974,439.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,099,118.8	4,939,610.3
210205	Эрүүл мэндийн даатгал	10,991,187.3	19,758,441.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,651,746.4</b>	<b>36,231,435.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,982,243.4	7,650,407.8
210302	Түлш, халаалт	15,892,357.0	24,111,999.2
210303	Цэвэр, бохир ус	4,777,146.0	4,469,028.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,406,589.7</b>	<b>45,813,395.3</b>
210401	Бичиг хэрэг	11,766,750.0	15,275,250.0
210402	Тээвэр, шатахуун	10,647,897.0	13,484,564.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,741,522.7	7,029,281.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,010,420.0	9,784,300.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	10,136,966.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	10,136,966.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,599,000.0</b>	<b>15,042,000.0</b>
210604	Урсгал засвар	15,599,000.0	15,042,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,265,400.0</b>	<b>8,868,900.0</b>
210702	Дотоод албан томилолт	7,265,400.0	8,868,900.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,627,125.0</b>	<b>13,871,064.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,270,000.0	11,987,950.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,225.0	335,214.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	44,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,150,000.0	1,500,000.0
210807	Газрын төлбөр	3,900.0	3,900.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,957,450.6</b>	<b>86,945,970.1</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,309,000.0	8,292,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,102,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,648,450.6	77,551,970.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,159,017.0</b>	<b>115,649,105.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,950,000.0</b>	<b>4,620,000.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,950,000.0	4,620,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>52,209,017.0</b>	<b>111,029,105.0</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(50,086,977.6)</b>	<b>158,495,093.3</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	10,136,966.0
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(10,136,966.0)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(50,086,977.6)</b>	<b>148,358,127.3</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>813,079,400.0</b>	<b>1,360,592,500.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,000,000.0</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,000,000.0</b>	<b>-</b>
120009	Бусад орлого	1,000,000.0	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>812,079,400.0</b>	<b>1,360,592,500.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>812,079,400.0</b>	<b>1,360,592,500.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	812,079,400.0	1,360,592,500.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>793,844,700.0</b>	<b>1,360,592,500.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>793,844,700.0</b>	<b>1,360,592,500.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>739,685,683.0</b>	<b>1,244,943,395.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>570,758,706.1</b>	<b>995,065,984.4</b>
210101	Үндсэн цалин	318,699,992.4	572,796,869.0
210102	Нэмэгдэл	163,492,770.5	280,644,906.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,058,941.2	62,336,500.0
210104	Урамшуулал	50,007,289.5	79,287,709.0
210105	Гэрээт ажлын хөлс	7,499,712.7	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,288,762.9</b>	<b>124,045,430.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,228,027.5	84,417,459.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,556,238.6	9,955,479.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,414,190.8	4,974,439.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,099,118.8	4,939,610.3
210205	Эрүүл мэндийн даатгал	10,991,187.3	19,758,441.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,651,746.4</b>	<b>36,231,435.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,982,243.4	7,650,407.8
210302	Түлш, халаалт	15,892,357.0	24,111,999.2
210303	Цэвэр, бохир ус	4,777,146.0	4,469,028.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,196,442.7</b>	<b>40,674,581.3</b>
210401	Бичиг хэрэг	12,185,100.0	14,813,300.0
210402	Тээвэр, шатахуун	10,949,900.0	13,692,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,741,522.7	7,029,281.3
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,079,920.0	4,900,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,039,000.0</b>	<b>15,042,000.0</b>
210604	Урсгал засвар	14,039,000.0	15,042,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,265,400.0</b>	<b>8,868,900.0</b>
210702	Дотоод албан томилолт	7,265,400.0	8,868,900.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,357,125.0</b>	<b>13,871,064.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.0	11,987,950.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,225.0	335,214.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	44,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,150,000.0	1,500,000.0
210807	Газрын төлбөр	3,900.0	3,900.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,128,500.0	11,144,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,128,500.0	10,042,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,102,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,159,017.0	115,649,105.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,950,000.0	4,620,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,950,000.0	4,620,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,209,017.0	111,029,105.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,209,017.0	111,029,105.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,234,700.0	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	19,234,700.0	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,234,700.0	-
2200	Дотоод эх үүсвэрээр	19,234,700.0	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,234,700.0	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(19,234,700.0)	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	275,943,025.0	30,030,193.5	549,748,236.4	855,721,455.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,943,025.0	30,030,193.5	549,748,236.4	855,721,455.0
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(50,086,977.6)	(50,086,977.6)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,943,025.0	30,030,193.5	499,661,258.9	805,634,477.4
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	275,943,025.0	30,030,193.5	499,661,258.9	805,634,477.4
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,943,025.0	30,030,193.5	499,661,258.9	805,634,477.4
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	148,358,127.3	148,358,127.3
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,943,025.0	30,030,193.5	648,019,386.2	953,992,604.7

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,360,592,500.0	1,249,563,395.0	111,029,105.0	91.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,360,592,500.0	1,249,563,395.0	111,029,105.0	91.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,355,972,500.0	1,244,943,395.0	111,029,105.0	91.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,083,381,800.0	995,065,984.4	88,315,815.6	91.8
210101	Үндсэн цалин	596,065,500.0	572,796,869.0	23,268,631.0	96.1
210102	Нэмэгдэл	307,890,300.0	280,644,906.4	27,245,393.6	91.2

210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,065,600.0	62,336,500.0	13,729,100.0	82.0
210104	Урамшуулал	103,360,400.0	79,287,709.0	24,072,691.0	76.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>135,422,700.0</b>	<b>124,045,430.3</b>	<b>11,377,269.7</b>	<b>91.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	92,087,500.0	84,417,459.3	7,670,040.7	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	10,833,800.0	9,955,479.7	878,320.3	91.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,416,900.0	4,974,439.9	442,460.1	91.8
210204	Ажилгүйдлийн даатгал	5,416,900.0	4,939,610.3	477,289.7	91.2
210205	Эрүүл мэндийн даатгал	21,667,600.0	19,758,441.0	1,909,159.0	91.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,465,100.0</b>	<b>36,231,435.0</b>	<b>11,233,665.0</b>	<b>76.3</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,531,900.0	7,650,407.8	4,881,492.2	61.0
210302	Түлш, халаалт	29,990,600.0	24,111,999.2	5,878,600.8	80.4
210303	Цэвэр, бохир ус	4,942,600.0	4,469,028.0	473,572.0	90.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,691,000.0</b>	<b>40,674,581.3</b>	<b>16,418.7</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	14,813,300.0	14,813,300.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	13,692,000.0	13,692,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,999,000.0	7,029,281.3	(30,281.3)	100.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	286,700.0	240,000.0	46,700.0	83.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,900,000.0	4,900,000.0	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,042,000.0</b>	<b>15,042,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	15,042,000.0	15,042,000.0	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,940,000.0</b>	<b>8,868,900.0</b>	<b>71,100.0</b>	<b>99.2</b>
210702	Дотоод албан томилолт	8,940,000.0	8,868,900.0	71,100.0	99.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,885,900.0</b>	<b>13,871,064.0</b>	<b>14,836.0</b>	<b>99.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,000,000.0	11,987,950.0	12,050.0	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	338,000.0	335,214.0	2,786.0	99.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	44,000.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.0	1,500,000.0	-	100.0
210807	Газрын төлбөр	3,900.0	3,900.0	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,144,000.0</b>	<b>11,144,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,042,000.0	10,042,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,102,000.0	1,102,000.0	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,620,000.0</b>	<b>4,620,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,620,000.0</b>	<b>4,620,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,620,000.0	4,620,000.0	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,360,592,500.0</b>	<b>1,360,592,500.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,360,592,500.0</b>	<b>1,360,592,500.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,360,592,500.0	1,360,592,500.0	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12.0</b>	<b>12.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	3.0	3.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.0	9.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9.0	9.0	-	100.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Прокурорын газар нь “Хууль тогтоох байгууллагын бодлогын үзэл санааг тууштай дэмжиж, хяналтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, зон олны эрх, эрх чөлөө, эд баялаг, түүхт уламжлалыг сахин хамгаалж, хууль тогтоомжийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- *Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх,*
- *Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах,*
- *Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх,*
- *Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих,*
- *Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.*

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *УИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 117 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар прокуроруудын албан тушаалын цалингийн хэмжээг,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд УЕПГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

МУЕП-ын 2021 оны А/179 дүгээр тушаалаар МУПЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148,358.1 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	14,280.0	12,209.7	(2,070.3)
Үндсэн хөрөнгө	791,354.5	941,782.9	150,428.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>805,634.5</b>	<b>953,992.6</b>	<b>148,358.1</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	805,634.5	953,992.6	148,358.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>805,634.5</b>	<b>953,992.6</b>	<b>148,358.1</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.  
Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл 12,209.7 мянган төгрөг болж, 2,070.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 59,397.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 11,455.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материалыг шилжүүлэн авсан болон 72,923.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 941,782.9 мянган төгрөг болж, 150,428.4 мянган төгрөгөөр өссөн нь 205,244.4 мянган төгрөгийн дансны үнэ бүхий Ланд-300, Соната 7 маркийн автомашин, 19,115.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг УЕПГ-аас үнэ төлбөргүйгээр орлогод авсан болон 22,000.0 мянган төгрөгийн Ниссан Патрол маркийн автомашиныг актлуулахаар УЕПГ-т шилжүүлснээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 920,480.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 440,112.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн тодотгол, зохицуулалт хийж, 1,360,592.5 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 135,422.7 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 15,042.00 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 47,465.10 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 40,601.00 мянган төгрөгөөр гэх мэт.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,360,592.5 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэн, гүйцэтгэлээр 1,249,563.4 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан 111,029.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,249,563.4 мянган төгрөг буюу 91.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 111,029.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,343,972.5	1,232,955.4	111,017.05	91.7
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,620.0	4,620.0	0.0	100.0
3	Байцаан шийтгэх ажиллагаа	12,000.0	11,988.0	0.12	99.9
	<b>Дүн</b>	<b>1,360,592.5</b>	<b>1,249,563.4</b>	<b>111,029.1</b>	<b>91.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “*нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна*” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130006401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “*Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана*” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Прокурорын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/71 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 868,713.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,687.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой бус сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Тээврийн хэрэгслүүдийн дугаарыг цэнхэр дэвсгэр бүхий тусгай дугаараар сольсон,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Аймгийн Прокурорын газрын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт тусгагдаагүй “Ахмадын сан”-д санхүүжилт шилжүүлсэн, бараа материалын шаардах хуудсыг тухай бүр хөтлөөгүй зэрэг нийт 21,068.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	18,068.0	1	18,068.0	100
	1	3,000.0	1	3,000.0	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>21,068.0</b>	<b>1</b>	<b>21,068.0</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Шатахууны урамшууллын **398.8** мянган төгрөгийг бүртгэл, тайланд тусгаагүй алдааг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт **1,257.0** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч, зөвлөмж өгөв.

#### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Бүрдэл дутуу анхан шатны баримтаар дараах **1,257.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Түлш, шатахууны зарцуулалтыг автомашин ашигласан албан тушаалтны гарын үсгээр бус жолоочийн гарын үсэг зурсан тооцооны хуудсаар хянаж, бүртгэл тайланд тусгасан,
- 1,257.0 мянган төгрөгийн бараа материалын орлого, зарлагын баримт болон шаардах хуудсыг холбогдох албан хаагчдын гарын үсгээр баталгаажуулаагүй.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хөдлөл өөрчлөлт бүрийг холбогдох албан тушаалтнуудын гарын үсгээр баталгаажуулан, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны урамшууллыг бүртгэл тайланд тусгаагүй	1	398.8	1	398.8			1	398.8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>398.8</b>	<b>1</b>	<b>398.8</b>			<b>1</b>	<b>398.8</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	1,257.0					1	1,257.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,257.0</b>					<b>1</b>	<b>1,257.0</b>				

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.